



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

СЭЛБЭГ МАТЕРИАЛ АВАХ ТУХАЙ

Монгол Улсын “ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17.1.1 , 17.1.7 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Тус албаны техникийн комиссын дүгнэлтээр албан ажлын хэрэгцээний 20-37 УБН номерийн “ Жинбэй” маркийн автомашинд 4 ширхэг шинэ дугуй худалдан авах шийдвэр гарсан тул түүнд шаардлагатай санхүүжилт болох, 620. 000 / зургаан зуун хорин мянган / төгрөгийг тээвэр, шатахууны зардлаас гаргахыг нябо / 3. Сэргэлэн /- д зөвшөөрсүгэй.

Хоёр. Албаны ажлын хэрэгцээний авто машины ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг техникийн комиссын дарга / Ч. Батсайханд / -д даалгасугай.



ДАРГА


Д. МӨНХЦОГ

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ
ТЕХНИКИЙН КОМИССЫН АКТ

2010.02.08

Агаарын чанарын албаны техникийн комиссын 2010 оны 2 дугаар сарын 8 ны өдрийн хурлын протоколыг үндэслэн, тус албаны ажлын хэрэгцээний 20-37 УБН номерын "Жинбэй" маркийн автомашины 4 дугуйг үзэж шалгав. Энэ 4 дугуй нь машиныг анх авахад 2007 оны 11- сард хамт ирсэн, нийт 37.600 км явсан цаашид ашиглах боломжгүй болсон тул акт тогтоов.

Техникийн комиссын дарга :



Ч. Батсайхан

Гишүүд:



Д. Даваадорж



О. Алтангарал



Г. Даваажаргал



Б. Сүхбаатар

Техникийн комиссын хурлын протокол №01

Оролцсон:

Агаарын чанарын албаны техникийн комиссын хурал 2010 оны 2 сарын 8 нд “Хангарьд ордны 401 тоот өрөөнд хуралдав. Тус хуралд техникийн комиссын дарга Ч.Батсайхан, гишүүд мэргэжилтэн Б. Сүхбаатар Д. Даваадорж , О. Алтангэрэл Г.Даваажаргал , жолооч Ж. Батбаатар нар байлцав. Хурлын ирц 100%

Хэлэлцэх асуудал:

Тус хурлаар албан ажлын хэрэгцээний 20-37 УБН номерийн “ Жинбэй “ маркийн автомашины 4 ширхэг дугуйг солих тухай.

Хурлын явц :

Дэд дарга Ч. Батсайхан :

Жолооч Батбаатарын гаргасан саналыг үндэслэн машины дугуй нь элэгдэж, нормоо гүйцээсэн, цаашид ажил үүрэг гүйцэтгэхэд боломжгүй болсон тул шинээр авах санхүүгийн асуудлыг шийдүүлэх хүсэлтийг дэмжиж байна.

Мэргэжилтэн Д.Даваадорж:

Аваарь осол аюулгүй байдлыг нь бодсон ч халзан дугуйг солихгүй бол болохгүй иймд саналыг дэмжиж байна.

Мэргэжилтэн О. Алтангэрэл:

Манай албаны бүх ажил үүргийг гүйцэтгэдэг унаа учраас 4 дугуй солих, албаны удирдлага санхүүд уламжлан, санхүүгийн асуудлыг шийдүүлэх саналтай байна. Мөн ЗЦГ –аас зуны ба халзан дугуйтай автомашиныг хөдөлгөөнд оролцуулахыг хориглох шийдвэр гарсан байгаа.

Шийдвэрлэсэн нь:

Нийт комиссын гишүүдийн 100 хувийн саналаар тус байгууллагын албан ажлын хэрэгцээний 20-37 УБН номерийн “ Жинбэй” маркийн автомашинд 4 ширхэг шинэ дугуй авах санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр тогтов.

Протокол хөтөлсөн:

Хүний нөөцийн мэргэжилтэн:



Б. Сүхбаатар